

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/131/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
Байхгүй	Error! Bookmark not defined.
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>55,449,126.00</u>	<u>15,883,240.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	55,449,126.00	3,300,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	52,149,126.00	
335	Бусад авлага	3,300,000.00	3,300,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,300,000.00	3,300,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	12,583,240.00
354	Хангамжийн материал	-	12,583,240.00
35470	Бусад хангамжийн материал	-	12,583,240.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,546,839,094.39</u>	<u>3,480,590,513.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,546,839,094.39	3,480,590,513.45
392	Биет хөрөнгө	3,525,561,761.07	3,452,019,450.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,495,048,697.00	3,495,048,697.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,268,251.68)	(94,487,271.84)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	8,235,000.00	24,008,135.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(359,666.65)	(3,011,875.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,735,000.00	15,735,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(301,614.60)	(3,883,072.92)
39217	Ном	14,472,597.00	18,609,839.20
393	Биет бус хөрөнгө	21,277,333.32	28,571,062.46
39301	Програм хангамж	880,000.00	8,674,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(58,666.68)	(559,437.54)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,456,000.00	20,456,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>3,602,288,220.39</u>	<u>3,496,473,753.45</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,193,554.00	16,023,827.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,193,554.00	16,023,827.00
413	Өглөг	4,193,554.00	16,023,827.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	11,776,047.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,193,554.00	4,247,780.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,598,094,666.39	3,480,449,926.45
51	Засгийн газрын хувь оролцоо	3,598,094,666.39	3,480,449,926.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,456,000.00	20,456,000.00
51101	Өмч: - төрийн	20,456,000.00	20,456,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,577,638,666.39	3,459,993,926.45
51210	Өмнөх үеийн үр дүн	3,577,638,666.39	3,577,638,666.39
51220	Тайлант үеийн үр дүн	-	(117,644,739.94)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,602,288,220.39	3,496,473,753.45

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,876,760,694.00	555,689,361.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,308,240.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,308,240.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	11,308,240.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	11,308,240.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,876,760,694.00	544,381,121.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,872,760,694.00	503,168,479.50
131005	Хөрөнгийн санхүүжилт	3,519,491,294.00	22,779,879.50
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,269,400.00	480,388,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,000,000.00	10,136,642.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	10,136,642.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	31,076,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	31,076,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	299,122,027.61	673,334,101.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	299,122,027.61	673,334,101.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	244,066,334.61	647,856,701.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	162,625,181.00	460,268,573.00
210101	Үндсэн цалин	120,733,943.00	418,901,973.00
210102	Нэмэгдэл	21,490,338.00	
210104	Урамшуулал	-	32,026,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,400,900.00	9,339,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,482,500.00	53,409,300.00
210201	Тэтгэврийн даатгал	48,434,800.00	37,584,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,702,400.00	3,956,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	3,165,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	940,500.00	791,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,404,800.00	7,912,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,193,554.00	33,331,026.00
210301	Гэрэл, цахилгаан	3,593,554.00	12,454,446.00
210302	Түлш, халаалт	-	16,876,800.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	3,999,780.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,970,670.00	2,617,200.00
210401	Бичиг хэрэг	543,700.00	590,700.00
210402	Тээвэр, шатахуун	2,071,700.00	1,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	804,300.00	976,500.00
210404	Ном, хэвлэл	29,500.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,121,470.00	
2105	Нормативт зардал	46,000.00	21,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,000.00	21,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	503,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	103,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,748,429.61	97,706,602.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	760,230.00	3,753,144.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,988,199.61	93,953,458.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,055,693.00	25,477,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,477,800.00	25,477,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,477,800.00	25,477,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,577,893.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,577,893.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	3,577,638,666.39	(117,644,739.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	3,577,638,666.39	(117,644,739.94)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
Тайлант үеийн үр дүн			0.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,456,000.00	3,577,638,666.39	3,598,094,666.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт			0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт			0.00

Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
Тайлант үеийн үр дүн		-117,644,739.94	-117,644,739.94
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,456,000.00	3,459,993,926.45	3,480,449,926.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,269,400.00	521,601,242.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	357,269,400.00	521,601,242.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	353,269,400.00	480,388,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	353,269,400.00	480,388,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,000,000.00	10,136,642.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	10,136,642.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	31,076,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		31,076,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	342,389,400.00	516,676,244.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	342,389,400.00	516,676,244.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,333,707.00	491,198,844.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,074,307.00	395,624,400.00
210101	Үндсэн цалин	176,183,069.00	354,257,800.00
210102	Нэмэгдэл	21,490,338.00	
210104	Урамшуулал		32,026,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,400,900.00	9,339,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,482,500.00	53,409,300.00
210201	Тэтгэврийн даатгал	44,672,900.00	37,584,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,702,400.00	3,956,200.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	3,761,900.00	3,165,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	940,500.00	791,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,404,800.00	7,912,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	32,776,000.00
210301	Гэрэл, цахилгаан		15,400,000.00
210302	Түлш, халаалт		16,376,000.00
210303	Цэвэр, бохир ус		1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,039,700.00	2,862,000.00
210401	Бичиг хэрэг	506,800.00	144,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,845,000.00	1,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	804,300.00	837,100.00
210404	Ном, хэвлэл	331,800.00	329,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,151,800.00	500,800.00
2105	Нормативт зардал	46,000.00	472,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,000.00	59,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		412,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	200,000.00
210604	Урсгал засвар		200,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	164,900.00
210702	Дотоод албан томилолт		164,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	606,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		206,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	691,200.00	5,084,144.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	691,200.00	5,084,144.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,055,693.00	25,477,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,477,800.00	25,477,400.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,477,800.00	25,477,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,577,893.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,577,893.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,880,000.00	4,924,998.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,880,000.00	4,924,998.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,880,000.00	4,924,998.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,880,000.00	4,924,998.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,880,000.00	4,924,998.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(14,880,000.00)	(4,924,998.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	511,464,600.00	511,464,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	511,464,600.00	511,464,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,987,200.00	485,987,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	395,624,400.00	395,624,400.00
210101	Үндсэн цалин	354,257,800.00	354,257,800.00
210104	Урамшуулал	32,026,900.00	32,026,900.00
210105	Гэрээт ажлын хөлс	9,339,700.00	9,339,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,409,300.00	53,409,300.00

210201	Тэтгэврийн даатгал	37,584,300.00	37,584,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,956,200.00	3,956,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,165,000.00	3,165,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	791,300.00	791,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,912,500.00	7,912,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,876,000.00	30,876,000.00
210301	Гэрэл, цахилгаан	13,500,000.00	13,500,000.00
210302	Түлш, халаалт	16,376,000.00	16,376,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,862,000.00	2,862,000.00
210401	Бичиг хэрэг	144,300.00	144,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,050,000.00	1,050,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	837,100.00	837,100.00
210404	Ном, хэвлэл	329,800.00	329,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,800.00	500,800.00
2105	Нормативт зардал	472,000.00	472,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,800.00	59,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	412,200.00	412,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	200,000.00	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	164,900.00	164,900.00
210702	Дотоод албан томилолт	164,900.00	164,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	606,100.00	606,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	206,100.00	206,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,772,500.00	1,772,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,772,500.00	1,772,500.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,477,400.00	25,477,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,477,400.00	25,477,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,477,400.00	25,477,400.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	511,464,600.00	511,464,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	480,388,600.00	480,388,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	480,388,600.00	480,388,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,076,000.00	31,076,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	31,076,000.00	31,076,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	47	47
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23
620003	Үйлчлэх ажилтан	18	18
620004	Гэрээт ажилтан	5	5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-
630001	Төрийн өмчит ЕБС		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	47	47
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24	24
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	18	18
650010	Гэрээт ажилтан	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,136,642.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,136,642.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,136,642.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,900,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,236,642.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,236,642.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,136,642.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,136,642.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,136,642.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хүүхдийн сурах, хөгжих, тоглох, амрах, амьдрах бүх орчныг бүрдүүлэх, бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжиж бага боловсрол олгоход үйл ажиллагаа чиглэгдэж байна.

Сургуулийн гол зорилго нь сургуулийн насны хүүхдүүдэд чанартай боловсрол олгох, хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөгчийн харьяа орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийдэг.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2021 онд шалгалт хийгээгүй байна.

Сургууль дотоод хяналтын нэгжтэй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Тус сургуулийн дотоод хяналтын талаар ойлголт олж авснаар туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 299.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105.8 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	55,449.1	3,300.0	(52,149.1)
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	-	12,583.2	12,583.2
Үндсэн хөрөнгө	3,546,839.1	3,480,590.5	(66,248.6)
Нийт хөрөнгө	3,602,288.2	3,496,473.8	(105,814.5)

Өр төлбөр	4,193.6	16,023.8	11,830.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,598,094.7	3,480,449.9	(117,644.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	<u>3,602,288.2</u>	<u>3,496,473.7</u>	<u>(105,814.5)</u>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Авлага дансны үлдэгдэл оны эцэст 3.3 сая төгрөг болж 52.1 сая төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн болон цалингийн ашгийн татварын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12.6 сая төгрөг болж 12.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тус сургууль нь 2020 онд байгуулагдсан, шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба тайлант онд 11.3 сая төгрөгийн хангамжийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 23.9 сая төгрөгийн материалыг худалдан авч, 22.6 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,480.6 сая төгрөг болж 66.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд үндсэн хөрөнгийн данс төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 4.9 сая, хөрөнгийн санхүүжилтээр орлогод авсан 22.8 сая буюу нийт 27.7 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үндсэн хөрөнгөнд 93.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр дансанд оны эхэнд гэрэл цахилгааны зардалд 3.6 сая, цэвэр бохир усны төлбөрт 0.6 сая, нийт 4.2 сая төгрөгийн үдэгдэлтэй байсан ба оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 7.3 сая, цалингийн ашигт 4.6 сая, гэрэл цахилгааны зардалд 0.6 сая, цэвэр бохир усны төлбөрт 3.6 сая, нийт 16.0 сая төгрөгийн өр төлбөртэй гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,480.4 сая төгрөг болж 117.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 117.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 555.6 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 3,321.1 сая төгрөгөөр буюу 85.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал санхүүжилт, хөрөнгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 372.2 сая төгрөгөөр буюу 125 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал, үдийн цайны зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга гараагүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны анх батлагдсан төсөв 520.0 сая төгрөг, тодотгосон төсөв 511.5 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 9.5 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Тээвэр шатахууны зардлыг 9.5 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 511.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна. Төсвийн зарлагын гүйцэтгэл 100 хувьтай байна.

Нийт төсвийн 77.3 хувийг цалин, 10.4 хувийг НДШ-ийн зардал, 6 хувийг тогтмол зардал, 5 хувийг үдийн цайны зардал, 1.3 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 10.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гэрэл цахилгааны зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 8.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургуулийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 96 мэдээллийг хугацаандаа оруулсан, 21 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь Шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн 1 дүгээр улирлын мэдээг оруулаагүй, 3 дугаар улирлын мэдээг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 501.7 сая төгрөгийн 13 орлогын гүйлгээг байршуулаагүй, өмнөх оны аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 1.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай 1 шийдвэр, 16.0 сая төгрөгийн өр үүсгэсэн 4 шийдвэрийг байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 39.3%, өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн 6.7 сая төгрөгийн 1 мэдээлэл, өр, авлага үүсгэсэн шийдвэрийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 40 дугаартай албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн ба өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулаагүй байна.

Тайлант оны байдлаар хэрэгжилтийг шалгаж үзэхэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан аудитын дүнгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан тул зөрчил арилгах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 530.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 529.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1.Ковид-19 цар тахлын үед тусгаарлах байранд ажилласан сургуулийн эмчид дээд шатны байгууллагын шийдвэрээр төсвөөс илүү цагийн хөлс тооцож олгохдоо 96 цагийн 0.6 сая төгрөгийг холбогдох нотлох баримтгүй илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон 0.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 529.6 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн 1 дүгээр улирлын мэдээг оруулаагүй, 3 дугаар улирлын мэдээг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 501.7 сая төгрөгийн 13 орлогын гүйлгээг байршуулаагүй, өмнөх оны аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, 1.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн 1, 16.0 сая төгрөгийн өр үүсгэсэн 4 шийдвэрийг байршуулаагүй, өмнөх онд шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргажээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.6, 6.4.8 дахь заалтууд болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд давтан гаргасан тул зөрчлийг арилгуулах талаар албан шаардлага өгөв.

2. Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль нь тайлант онд 511.5 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр 511.5 сая төгрөгийг зарцуулсан ба үүнээс 505.4 сая төгрөг нь байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой цалин, тогтмол зардал, хоол, хүнс, үдийн цайны зардлууд байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд заасны дагуу тэвчиж болох бусад урсгал зардал 6.0 сая төгрөгийг 10 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр хэмнэж ажиллах ёстой боловч хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэж зарцуулаагүй 0.6 төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

3. Боловсролын салбарын ажилтны орон тооны жишиг нормативт байхгүй хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулж төсвөөс 10.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ. Энэ нь оны эцэст нийгмийн даатгалын шимтгэл, татварт нийт 11.8 сая төгрөгийн өглөгтэй гарахад нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-т “*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*”, Бага, дунд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д “*Ерөнхий боловсролын сургуульд захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан ажиллана*”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын салбарын ажилтны орон тооны жишиг нормативыг баримталж ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Эмийн зардлаас 0.04 сая, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 0.2 сая, дотоод албан томилолтын зардлаас 0.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 0.1 сая, урсгал зардлаас 0.2 сая, нийт 0.7 сая төгрөгийг зардлын бүлэг хооронд зарцуулах зөвшөөрөл авалгүй цалингийн зардалд гүйлгэж, цалингийн ашгийн татварын тооцоонд шилжүүлсэн.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэн”, 42.3.1-д “төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид, хүргүүлэх” гэсэн заалтыг баримталж, зөрчлийг арилгаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү..

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль	4	530.9			1	0.6	3	529.6	1	0.7